

# МАНМИН МЭДЭЭ

Номер 23 2012 оны Зургадугаар сарын 10

## Бурханы Ариун Гэгээн Сургаал Исламын Пакистан Улсад Гүн Нэвчин Оров!

Доктор Жаерок Лее гуай Пакистаны Үндэсний Сүмийн Удирлага  
болон Олон Улсын Бишоп Зөвлөлийн Даргаар Томилогдов



■ Фото 1: Ойролцоогоор 10,000 хүн оролцсон Амин Ус Сүмээс зохион байгуулсан Агуу Гайхамшигт Эдгээлтний Крусайд үйл ажиллагаа. (Венуе: ФГА Лахоре дахь Талбай) ■ Фото 2: Пастор Таесик Гил гуай Лахоре дахь Агуу Гайхамшигт Эдгээлтний Крусайд дээр сургаал айлдаж байгаа байдал. (зургын зүүн тал дээр) ■ Фото 3: Тарик Гил ах толгойн өвчинөөсөө ангижирсан эдгэрсэн тухай гэрчиллээ хуваалцаж байгаа нь. ■ Фото 4: Манмин сүмд нэгдэн орцгоосон салбар сүмүүдийн пасторууд

Исламын Пакистан улсад хийгдсэн бурханы ариун гэгээн сургаал үнэхээр гайхамшигтай байв.

2012 оны Гуравдугаар сарын 12-ноос 30-ны хооронд Пакистан улсад номлолын үйл ажиллагаа явагдав. Пастор Таесик Гил (Даежеон Манмин Сүм) Лахоре, Сиалкот болон Файсалабад хэмээх газруудад айлчилаж, долоон Пасторын Семинарууд болон арван Гайхамшигт Эдгээлтний Крусайдыг тус тус зохион байгуулав (Үйлс 19:11-12). (Холбогдох түүх 4-р хуудсанд)

Энэхүү номлолын үйл ажиллагаа нь Пакистаны Сүмийн Ассемблеи болон Методист Ассемблей хэмээх Христийн хоёр ассемблейн бишопуудын хүсэлтээр зохион байгуулагдав. Пасторын Семинарууд болон

Гайхамшигт Эдгээлтний Крусайд үйл ажиллагаанууд нь орон нутгийн цагдаагийн ажилтануудын тусламжтайгаар тус тус зохион байгуулагдав. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд олон гайхамшигт зүйлс тохиолдов. Манмин сүмийн салбар өргөжин тэлж Методист Ассемблеи гэх мэт 56 сүмүүд орцгоон, нийт 88 сүмүүд бүртгэгдэн Манмин сүмийн ассемблейд орцгоов.

Хэдий Бишоп Удирдах Зөвлөл болон Үндэсний Сүмийн Удирдлагад нийт 80-аад бишоп ба төлөөлөгч удирдагч ажилтанууд байдаг боловч төсөөлөшгүй гайхамшигт үйл болон тэд Ахлах Пастор Доктор Жаерок Лее гуайг өөрсдийн олон улсын удирдах зөвлөлийн даргаар томилов. Бишоп Уйсаф Сохайл гуай, Бид түүнийг

сонгосоны учир шалтгаан нь түүний агуу гайхамшигт сүнслэг удирдлага нь Пакистаны пасторуудыг сүнслэг бурханлгаар удирдаасай хэмээн хүсч байсанд юм хэмээн хэлэв.

Бурханы заан тунхаглаж байсан агуу гайхамшигт сургаал болох үнэний сургаал номлолыг сурч мэдэн авсанаар Бурхан бүх хүмүүсийг тэрхүү гайхамшигт үнэний жимснээс хүртээсэй хэмээн хэлсэний дагуу тийнхүү Пакистанд бий болов. Доктор Жаерок Лее гуай Пакистаны Нэгдсэн Крусайд 2000 хэмээх үйл ажиллагааг зохион байгуулан Их Эзэн Есүс Христийг заан тунхагласан билээ. Тэрхүү крусайд үйл ажиллагаа нь Исламын орнуудад зохион байгуулагдаж байсан Христийн үйл ажиллагаа байсан ба агуу том хэмжээнд явагдсан юм.

Тэр цаг мөчөөс хойш Пасторуудын Семинарууд болон Эдгээлтний Крусайд үйл ажиллагаанууд удаа дараалан зохион байгуулагдсан билээ. Пастор Таесик Гил гуай Пакистанд 13 удаа айлчилан очсон ба нийт 11 хотуудад семинар болон уулзалтууд зохион байгуулсан билээ. Мөнтүүнчлэн, Манмин сүмийн үйл ажиллагаа нь ГХШ (Глобал Христийн Шүлжээ) ТВ-ийн нэвтрүүлгүүд, Доктор Жаерок Лее гуайн номууд, Урду хэл дээрх Манмин Сүмийн Мэдээ болон МОУС (Манмин Олон Улсын Семинар)-ын семинаруудаар тус тус тунхаглагдсаар байдаг билээ.

ГСН ТВ-ын нэвтрүүлгүүд нь бурханы ариун гэгээн сургаал номлолуудыг заан тунхагладаг ба Пакистаны Исаак сансрын ТВ-

ын станцаар (Ерөнхийлөгч Пастор Анвар Фазал) нийт 73 хотуудад ба нийт 253 кабел ТВ-ын шүлжээгээр тус тус цацагдан тараагддаг. Энэхүү үйл ажиллагаа нь олон мянган Мусламчуудыг Христийн шашинд орох боломжыг бий болгож байдаг ба мөнтүүнчлэн хөрш зэргэлдээ орнуудад бурханы сургаал номлолыг заан тунхаглахад тус нэмэр болдог билээ.

Хүн төрөлхтөний тусын тулд амралт нойргүй анхааралаа тавьж байдаг Бурхант Тэнгэрлэг Эцэгтээ алдар сууг өргөн баринам.

Ариун гэгээн алчуурт эдгээлтний номлолын үйл ажиллагаагаар олон мянган хүмүүс Бурхан болон Есүс Христийн тухай олж мэдэжээсэн билээ. Пасторууд өөрсдийнхөө сүнслэг байдлаа сэргээн шинэтгэсэн юм.

«Загалмайн Үг» цувралаас -(21)

# Энэ Нууцлаг Сайн Мэдээ нь Юутай Сайхан бэ!

«Тиймээс эр хүн эцэг эхээ орхиж, эхнэртэйгээ нийлдэг. Тэр хоёр нэг махан бие болно». Энэ нууц бол агуу билээ. Гэвч би Христ болон чуулганы тухай хэлж байна.» (Ефис 5:31-32)

Хүн өсөж торнин эхнэр аван нэг гэр бүл болон гэрээсээ холдон одоодоо эцэг эхээсээ салан явдаг гэдгийг хүн болгон мэддэг б Гэвч Библи дээр Нууцлаг сайн мэдээ нь үнэхээр гайхамшигтай билээ хэмээн хэлсэн байдаг нь гэр бүлийн талаар биш Христийн хуримын нөхрийн сайн анд болж байгааг дурдаж хэлж байгаа юм.

Энэ дэлхийг бид орхин явахдаа Есүс Христийн сайн нөхөр анд болон яг л хүн эцэг эхээ орхин эхнэртэйгээ суун нэг гэр болдог шиг явах нь юутай сайхан гайхамшигтай вэ? Их Эзэнтэй нэгдэн нэг бие махбодь хэрхэн болох вэ?

## 1. Есүс Христийг Итгэлээр хүлээн авсаныхаа дараа Ариун Сүнснийг авах нь

Анхны хүн Адам маань Бурханы сургаал тушаалыг зөрчин дуулгаваргүй байсанаас болж бүх хүн төрөлхтөн гэм нүгэлтэн болцгоон муу ёрын сүнсний эрх мэдэлд орцгоосон билээ (Иохан 8:44; 1 Иохан 3:8). Гэвч Есүс Христийг хүлээн зөвшөөрөн гэм нүглээсээ ангижиран Ариун Сүнснийг хүлээн авцгаасаны дааа Бурханы сүнсэлэг хүүхэд болцгоон тэнгэрийн хаант улсад орох боломжтой болдог билээ.

Иоханы 3:6-д, «Бие махбодиор төрсөн хүн болгон Сүнсээрээ дахин төрөх хэрэгтэй билээ» хэмээн хэлдэг ба Ариун Сүнс нь бидний зүрх сэтгэлд нэвчин орж бидний үхмэл байсан сүнснийг сэргээдэг билээ. «Сүнсээр дахин төрөх» гэдэг нь Их Эзэний нэрийг өөртөө хүлээн аван ариун үнэнээр зүрх сэтгэлээ дүүргэхийг хэлж байгаа юм. Сүнсээр дахин төрөн ариун үнэнээр зүрх сэтгэлээр дүүргэсэн хүмүүс Бурханы хүүхдүүд болцгоон Бурханг «Аваа» хэмээн дууддаг. (Ром 8:15; Галат 4:6).

Ариун Сүнснийг хүлээн аваад Ариун Сүнсний төрөлттэй золгон Бурханы хүүхэд болох үйл явцыг сайтар ойлгохын тулд хүний зүрх сэтгэлийг нарийн сайтар авч үзье.

Нэгт, хүний зүрх сэтгэл нь мэдээж үнэний зүрх сэтгэл болон худал зүрх сэтгэлд буюу цагаан сэтгэлт зүрх ба 'хүйтэн цэвдэг хар сэтгэлт' хэмээн хуваагдан өөрчилөгддөг билээ.

Бурхан хүний хамрын нүх рүү амь хайрлан үлээж оруулсан ба хүн тэр цаг мөчөөс хойш амин үрийг эзэмшдэг болов. Бурхан хүний зүрх сэтгэлд үнэнийг суулгасан ба тэр үнэн нь Адамын амин үрийн үнэн нь түүний сүнс болон амь нь болсон билээ.

Цаг хугацаа улиран өнгөрсөний дараа Адам нь гэм нүгэл үйлдэн Бурханаас харилцаа холбоо тасарсан ба үүнийг муу ёрын сүнс Сатан нь ашиглан түүнд хорон муу болон бузар булайг хийлгэн улам их гэм нүгэлтэн болгов.

Үүний дагуу, өөр нэгэн зүрх сэтгэл, зүрх сэтгэлийн ухаарал бий болов. Зүрх сэтгэлийн ухаарал гэдэг нь анх хүн бий болсоныхоо дараа маш их



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

мэдээлэлүүдийг хүлээн авахдаа анхны мэдээлэлээсээ өөр зүйлтэй тулгарах үед ялгарагдан гарах оюун ухааны ялгарал юм. Хүн бүр үнэн худал болон өөр өөрийн гэсэн оюун ухааны шийдийг гарах боломжтой байдаг ба энэ нь зүрх сэтгэлийн ухаарал юм. Тиймээс, нэг хүний оюун ухааны ухаарал нь тухайн цаг мөч болон өмнөх амьдралын нөхцөл байдлаасаа шалгаалан өөр өөр оюун ухааны ухааралтай байдаг.

Дээр дурдсан гурван төрлийн-чин үнэнч зүрх сэтгэл, худал хуурмаг зүрх сэтгэл ба оюун ухааны ухаарал хэмээх зүрх сэтгэлийн төрлийн талаар ярилцсан ба Бурханы хүн төрөлхтөний зүрх сэтгэлд ургуулан бий болгосон чин үнэнч зүрх сэтгэл нь хүний оюун ухаанаар солигдон гэм нүгэл өнөө үед маш их хийгдэх болов.

## 2. Ариун Сүнс Бидний Зүрх Сэтгэлд Шинэ Амьдралыг Хайрлаж Байдаг

Бурханы хүн төрөлхтөнд анх хайрлан өгсөн амин үрийн чин үнэн зүрх сэтгэл нь анх хүн Бурхантай харилцах үед байдаг байв. Адамын гэм нүгэл үйлдсэнээс хойш хүн төрөлхтөний Бурхантай харилцах холбоо нилээд хүндэрсэн ба худал хуурмаг хүний сэтгэлд гүн нэвчин орсон тул хүний амин үр нь нилэхүүдээ худал хуурмагаар бүрхэгдэв.

Амин үр нь, худал хуурмагаар бүрхэгдсэн тул идэвхгүй бүрэг хойрго болон ямар ч нэмэргүй болон үхмэл байдалд оров. Бурхантай харилцаа холбоотой байх байдал нь маш хол тасархай болон амин үр нь идэвхгүй болон хүн төрөлхтөний сүнс нь үхмэл байдалтай болсон билээ. Энэ нь угтаа яг л хатаж хорчийсон ургамал мэт болон голдоо л амьтай мэт болсон байв.

Хүний үхмэл байсан сүнс нь хэзээ сэргээгдсэн бэ? Ариун Сүнснийг бид хүлээн авах үед бидний сүнс сэргээгдсэн билээ. Бурханы сургаал номлолыг заан тунхаглах үед хүний зүрх сэтгэл ариун гэгээнээр гэрэлтдэг билээ. Тухайн үед үнэн болон чин үнэнч сайхан сэтгэл нь түүнд шингэн

орж Есүс Христийг Аврагчаа хэмээн хүлээн зөвшөөрдөг билээ. Тэр үед Бурхан Ариун Сүнсээ илгээдэг ба Ариун Сүнс нь хүний зүрх сэтгэлд нэвчин ордог.

Хүний амин үр нь Ариун Сүнсний нэгдэн орох үед идэвхтэй байдалд орон зүрх сэтгэлийн чичирхийлэлтийг хүлээн авдаг. Адамын хийсэн гэм нүглээс болж Бурхантай тасарсан холбоо нь эргэн сэргээгдэж ариун үнэнээр дүүргэгдэн дахин сэргээгддэг билээ. Худал хуурмаг, үзэн ядалт, их зан, хэрүүл маргаан, огцом уур авир болон садар самуун явдал нь ариун үнэн, бусдад үйлчилэх сайхан сэтгэл болон энх тунх байдлаар солигдон ордог билээ.

## 3. Худал Хуурмаг Зүрх Сэтгэлээ Орхин Ариун Үнэнч Хүн Болох нь

Ариун Сүнсний сүнснийг хүлээн аван сүнсэлэг хүн болох үйл явц нь залбиралаар хийгдэж байдаг билээ.

Чин сэтгэлийнхээ угаас хийсэн залбирал нь Бурханы энэрэл эвээлийг хүлээн аван өөрийн зүрх сэтгэлийнхээ гэм нүглийг нарийн сайн ойлгож авдаг билээ.

Хэрэв хүн өөрийн зүрх сэтгэл дэхь гэм нүгэл хорон муу санаагаа устган үгүй болгохгүй юм бол хэдий мэрийн чармайн залбирсан ч гэсэн хий хоосон байх болно. Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг. (2 Коринт 10:5).

Учир нь махан биеийн дагуу байгчид нь махан биеийн юмсыг боддог. Харин Сүнсний дагуу байгчид нь Сүнсний юмсыг боддог. Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой (Ром 8:5-6). Бурханы ариун гэгээн үйлийг өөртөө бий болгохгүй бол тэр хүн зүрх сэтгэлдээ хий хоосон байх болно.

Хэдий хүн зүрх сэтгэлээсээ худал хуурмагыг хөөн зайлуулсан ч гэсэн энэ нь эцэс төгсгөл биш ба хүн улам цаашлан гэм нүгэлт үйлээ оюун ухааны ухаарлаасаа хөөн зайлуулах хэрэгтэй болдог. Оюун ухааны ухаарал нь хүний

өөрийн мэдэлгүй зүйлээс урган гарч байдаг тул хүн өөрөө ч сайн мэддэггүй.

Оюун ухаан дахь худал хуурмаг нь Бурханы үйлтэй үл нийцдэг ба хүний нүдээр бол үнэн зөв мэт санагдаж байдаг. Тийм ч учраас энэ нь хүн өөрөө үүнийг олж мэдэх боломжгүй байдаг билээ. Хүнийг өөрөөр нь ухааруулан худал хуурмагыг олж мэдүүлэн Бурханы өөрийн чин үнэнч хүүхдээ болгодог билээ. Иоб чин үнэнч зарчимч хүн байсан тул тэрбээр хүн хүчир зүйлтэй тулгарахдаа өөрийн оюун ухаандаа тулгуурлах биш харин Бурханы чин үнэн дээр тулгуурласан билээ. Чин үнэнч сэтгэлийг даган Ариун Сүнсний хүчээр Бурханы Үгийг өөрийн амьдралд нэгтгэн оруулсанаар бид гэм нүглээсээ ангижиран ариун гэгээн болцгоодог.

## 4. Их Эзэнтэй Нэгдсэнээр Бид Агуу Гайхамшигт Адислалуудыг Хүлээн Авдаг

Өөрсдийн гэм нүгэлт байдлаар орхин Ариун Сүнсээр төрөхдөө бид худал хуурмаг байдлыг өөрсдөөсөө хөөн зайлуулдаг ба ингэснээрээ бид Их Эзэний чин үнэнч хүүхэд болдог билээ.

1 Иоханы 2:12-д, итгэлийн томожилтонд хүрсэн байдаг тухай дурдан бичсэн байдаг ба (Ром 12:3)-д Их Эзэний чин үнэнч хүүхэд болоход хүний томожилтонд дөхөн ойртож байна хэмээн бас дурдан хэлсэн байдаг.

Есүс Христийг хүлээн зөвшөөрөн, Ариун Сүнснийг хүлээн аван авралыг олж авсанг 'бяцхан хүүхдийн итгэл' хэмээн хэлдэг ба хүн үнэнийг олж мэдэж авахдаа 'бяцхан хүүхдийн итгэл' мэт хүлээн аван, Бурханы үгийг амьдралдаа даган мөрдсөнөөр 'залуу хүүхдийн итгэлтэй' болдог ба улам их итгэлээ хөгжүүлэн дээшилүүлсэнээр 'өвөг дээдсийн итгэлтэй' мэт болцгоодог билээ.

Өвөг дээдсийн итгэлтэй болоход бид Их Эзэнтэйгээ улам сайн ойртсон байдаг ба аврал болон залбиралынхаа хариултыг хүлээн авцгаадаг билээ (1 Иохан 3:21-22). Ариун Сүнсний төрөлтийг өөрсдийн амьдралдаа бий болгоцгоон Их Эзэнтэйгээ нэгдэн адил болон энэ амьдралдаа аз жаргалыг хүлээн аван тэнгэрийн хаант улсын дээд орон болох Шинэ Иерусалимд орох болтугай хэмээн Их Эзэн Есүс Христийн нэрийн өмнөөс залбиран гуйнам!

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
<http://www.manmin.org/english>  
e-mail: manminministry@hotmail.com

Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин

# Ариун Сүнсний Агуу Гайхамшигт Үйл болон Ариун Гэгээн Номлол Тайландад Бий Болсон нь!



Арван хоёр өдрийн турш Тайландад Пасторын Семинарууд болон Алчуурт Эдгээлтийн Уулзалтууд тус тус зохион байгуулагдсан юм. Манмин Сүмийн агуу гайхамшигт сургаал номлолууд тараан тунхаглагдаж Вант Улсын Цэргийн Академи болон Залуучуудын Хорих Газар агуу гайхамшигт тоглолтуудыг хийж үзүүлэв. ■ Фото 1: Гуравдугаар сарын 15-нд болсон Вант Улсын Цэргийн Академи ■ Фото 2: Пастор Сунгчил Лее гуай (урьд талын эгнээний зүүн талаасаа гурав дахь нь) болон Номлогч Жаевон Лее (зүүн талаасаа хоёр дохь нь) ба Тайландын цэргийн генералууд ■ Фото 3: Гэрлийн Дуу Эгшиг Найрал Дуулаачид

Буддын шашинтан нь 95% болох Тайланд улсад Ариун Сүнсний үйл ажиллагаа болон Бурханы ариун гэгээн сургаал мэндлэн бий болов.

Гуравдугаар сарын 9-ноос 20-ны хооронд, Пастор Сунгчил Лее гуай болон Манмин Төв Сүмийн Урлагын Комиссын Гэрлийн Дуу Эгшиг хэмээх найрал дуучид Тайланд улсад номлолын айлчилалаа хийв. Тайланд улсын хойд хэсгээр Пасторуудын Семинар, Алчуурт Эдгэрэлтийн Уулзалт, Вант Улсын Цэргийн Академи болон Банубека ба Банккаруна Залуучуудын Хорих Газруудад Пастор Сунгчил Лее гуай тус тус яриа өгөв. Гэрлийн Дуу Эгшиг найрал дуулаачид Бурханы алдар сууг магтан дуулсан гайхамшигт тоглолтоо Тайланы Эзэн Хааны төрсөн өдрийн 84 жилийн ойн баярт дуулан оролцов.

Манмин Төв Сүмий энэхүү айлчилалаараа Тайландын засгийн газрын ажилтанууд, цэргийн генералууд болон сурвалжлагч нарын анхаарлыг татан олны танил болцгоов. Мөнтүүнчлэн, Пасторын семинарууд Кампуж болон Лаос улсуудад удахгүй зохиогдохоор болсон нь Индочина орнуудад Бурханы сургаалыг үндэслэн байгуулахад маш их тус дөхөм болох билээ.

2009 оны Арваннэгдүгээр сараас хойш Манмин сүмийн номлогч нараа

илгээж байсан ба Чианг Рай Манмин Сүмийн Номлогч Жаевон Лее гуай болон Сунок Лее нар өөрсдийн ажил үйлсээ зориулан Тайланд хэлэн дээрх ном судруудыг тараах, Пасторуудын Семинаруудыг явуулсаар байв. Тэдгээр номлогч нарын тусламжтайгаар маш олон сүмүүд Манмин Сүмд нэгдэн орцгоосон юм. Мөнтүүнчлэн, ГСН ТВ-ын (www.gcntv.org) програмууд, Доктор Лее гуайн Бурханы сургаал номлолууд нэвтрүүлгийг Тай Ком 5 хэмээх хэвлэл мэдээлэлийн ТВ суваг цацан явуулдаг билээ. Маш олон хүмүүс тэдгээр програмуудыг үзэн сонирхдог тул Бурханы сургаал номлол нь олны сонорт үтэр түргэн хүрцгээж байдаг билээ. Цаашилан хэлбэл, тэдгээр хоёр номлогч нар Бурханы Манмин Сүмийн Мэдээ болон агуу гайхамшигт сургаалуудыг гардан тараан хүмүүст өгдөг ба Тайланд хэлнээ орчуулсан материалууд болон Тайланд улс даяар цацагдан тараагддаг СРУ Радио Станцаар Муанмар болон Лаос улснаа тус тус номлон цацан тараагдах билээ.

Доктор Лее гуайн алчуурт залбиралын үйл ажиллагаагаар агуу гайхамшигт зүйлс бий болов. Алчуурт залбиралын үйл ажиллагааны дараа хий хоосон бөө мөргөл үйлддэг хүмүүс хүртэл бурханы сургаал номлолыг хүлээн авав (Үйлс 19:11-12). Пастор Сунгчил Лее 2011 оны Хоёрдугаар

сар болон 2009 оны Есдүгээр сард Тайландын олон хотуудаар айлчилан уулзалт үйл ажиллагаануудыг зохион

явуулан Бурханы алдар сууг магтан дуулав. Маш олон хүмүүс эдгэрэл адислалуудыг хүлээн авцгаав.



СРУ Радио Станц-д Хийсэн Айлчилал ба Пасторын Семинар, Хойд Хэсгээр Хийсэн Алчуурт Эдгээлтийн Уулзалтууд

Гуравдугаар сарын 10-ны Бямба Гариг

Чианг Рай Манмин Сүмийн Нэг Жилийн Ойн Баярт Үйл Ажиллагаа ба Алчуурт Эдгээлтийн Уулзалт

Гуравдугаар сарын 11, Ням Гариг

Вант улсын Цэргийн Академи дээрх Уулзалт

Гуравдугаар сарын 13, Пүрэв Гариг

болсон Вант Улсын Цэргийн Академи

Гуравдугаар сарын 15-нд

Эзэн Хааны 84 Жилийн Ойн Баярын Үйл Ажиллагаа ба Манмин Холбооны Сүм Дээр Хийсэн Алчуурт Эдгээлтийн Уулзалт

Гуравдугаар сарын 17, 18-ны Бямба болон Ням Гариг

## Улаанбаатар Манмин Сүм

### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

# Бурханы Хайраар Пакистан Улс Өөрчилөгдсөн нь



Бурхан бүх хүмүүсийг аврах хүсэлтэй байдаг билээ. Хэдий тийм ч Пакистанд ихэнхи хүмүүс нь Муслам хүмүүс байдаг. 2012 оны Гуравдугаар сард 18 шөнө ба 19 өдрийн хугацаанд Манмин номлолын хүмүүс үйл ажиллагаагаа явуулав. Тус багынхан Загалмайн Сайн Мэдээ хэмээх агуу гайхамшигт сургаал номлолоороо маш олон сүмийн пасторуудыг сүнслэг байдлаар сэргээн амилуулав. Доктор Лее гуайн залбирал үйлдсэн алчуураар агуу гайхамшигт зүйлс бий болсон ба Ариун Сүнсний үйл ажиллагаа явагдав. Библи дээрх дагалдагч Пол гуайн Үйлсийн 19:11-12-д заасаны дагуу Бурхан амьд гэсэнг баталгаажуулсан олон гайхамшигт үйлсийг тэд үзүүлэн гаргав.

## ◆ Лахоре Гайхамшигт Эдгээлтийн Крусайд үйл ажиллагаанд 10,000 хүмүүс хүрч ирцгээв

Пастор Таесик Гил гуай ба түүний багынхан Пакистан улсын нийслэл Исламабадд Гуравдугаар сарын 12-нд хүрэлцэн ирцгээж Гуравдугаар сарын 13-нд Эдгээлтийн Крусайд Үйл Ажиллагааг зохион явуулав.

Гуравдугаар сарын 14-ний өглөө Даежеон Манмин Сүмийн Пастор Таесик Гил гуай 'Бурхан Яагаад Сайн Мууг Таниулагч Модыг Бий Болгосон Учир Шалтгаан' болон 'Есүс Христ Яагаад Бидний Цорын Ганц Аврагч Юм бэ?' хэмээн сургаал номлолуудыг айлдав. Тэдгээр сургаал номлолууд нь Доктор Жаерок Лее гуайн 'Загалмайн Сайн Мэдээ' номууд дээр үндэслэсэн байв. Хүрэлцэн ирэгсэд тус уулзалтыг маш их баяр хөөртэйгөөр хүлээн авч сонсоцгоов. Үдээс хойш, Пакистаны бишоп болон пасторууд Манмин Сүмийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байдалтай танилцажээ. Тэд Доктор Жаерок Лее гуайг Пакистан улсын Үндэсний Сүмүүдийн Бишопын Удирдлагын Зөвлөлийн Олон Улсын Гишүүчилэлийн Даргаар сонгон шалгаруулав. Орой нь, Агуу Гайхамшигт Эдгээлтийн Крусайд үйл ажиллагааны Бурханы Сургаалын Ассемблейн газар 10,000 гаруй сонирхогчид хүрэлцэн ирцгээв. Пастор Таесик Гил түрүү жилийн Арваннэгдүгээр сард эдгэрэл адислалыг хүлээн авсан Сана Хахн эгчийн тухай дурдан хэлэв. Түүний хэвлийд байсан хүүхэд нь амьгүй болсон байсан боловч алчуурт адислалын залбиралаар хэвлийд байсан хүүхэд амь орон эрүүл саруул хүүхэд төрөн гарсан билээ. Бурханы агуу гайхамшигт алдар сууг магтан дуулцаж байсан хүмүүсийн гэрчиллүүдийг сонсоод хүмүүс маш их баярлан алгаа ташицгааж байв.

## ◆ Загалмайн Сайн Мэдээ нь Сиалкотод тунхаглагдсан ба Пакистанд тийнхүү номлол эхлэв

Гуравдугаар сарын 15-наас 16-нд Пакистаны Сиалкот сүмд хоёр удаа Пасторын Семинарууд зохион явагдсан ба тийнхүү Пакистанд Бурханы сургаал номлол эхлэв. Пастор Гил гуай Загалмайн Сайн Мэдээний сургаал номлолыг хүн төрөлхтөний тусын тулд тунхаглан сургаал айлдав. Гуравдугаар сарын 17-нд, Сиалкотод Эдгээлтийн Агуу Гайхамшигт Крусайд үйл ажиллагаанд ойролцоогоор 3,000 хүмүүс хамрагдан орцгоов. Пастор Гил гуайн алчуурт адислалын залбиралаар эдгэрэлийг хүлээн авцгаасан хүмүүс индэр дээр гарч ирэн гэрчиллүүдээ хуваалцажээ. Үйл ажиллагааг зохион байгуулагчид тайзан дээр олон хүмүүс зогсоноос болж гэмтэж магадгүй хэмээн болгоомжилон гэрчиллүүдээ хуваалцажээ. Индэр дээр гарч ирж байгаа хүмүүсийг таслан зогсож байв. Насеен хэмээх 50 настай нэгэн эмэгтэй чихрийн шижинг өвчинөөс болж хараагүй болсон хараа орсон ба Мехмоод хэмээх 45 настай залуу хөлөө хугалсанаас болж хагалгаанд орон тахир дутуу болсон байсан хүн бүрэн эдгэрэлийг олж авав. Тэрбээр таягаа шидэн хаваад алхаж явж байв. Бурхандаа алдар суу талархалаа өргөн барьцааж байсан маш олон хүмүүс байв. Гуравдугаар сарын 18-нд Бурханы Тринити Сүмийн пастор Бишоп Самуел Первез 'Есүс Христ' хэмээх сэдэвт сургаал номлол айлдав.

## ◆ Файсалабад болон Исламабадад агуу гайхамшигт үйл ажиллагаа биелэлээ олцгоов

Гуравдугаар сарын 19, 20-нд Файсалабадын Пасторуудын Семинарууд Пакистаны Методистын Нэгдсэн Ассемлеин Пастор Башир Л. Маллын удирдлагаар зохион байгуулагдав. Тус семинарт оролцсон нэгэн пастор, «Христийн амьдралаар амьдардаг ч гэсэн надад маш олон үл ойлгох асуудлууд байдаг байсан ба өнөөдөр бүх хариултуудаа хүлээн авав» хэмээн хэлэв. Өөр нэгэн пастор бидэнд, «Есүс ба Есүс Христ гэдэг нэрүүдийн учир шалтгаан болон Есүс яагаад Мариаг 'эмэгтэй' хэмээн дууддаг байсан талаар олж мэдэж авав» хэмээн хэлэв.



Лахоре



Сиалкот



Исламабад



Равалпинди



Хидерабад

Гуравдугаар сарын 22-нд, Исламабадын Есүс Дуудлага хэмээх сүмд Эдгэрэлтийн Крусайд үйл ажиллагаа явагдав. Гуравдугаар сарын 23-нд, Пасторуудын Семинарууд Исламабадад, Равалпини болон Эдгээлтийн Агуу Гайхамшигт Крусайд үйл ажиллагаа явагдав. Нэгэн пастор, эмч ажилтан хүн ба ийм утга учиртай сургаал номлолыг хэзээ ч сонсож мэдэж байгаагүй билээ хэмээв. Эдгээлтийн Агуу Гайхамшигт Крусайд уулзалтанд өсөлт бойжилт нь хэвийн биш тувт хөл нь майга болж арьс нь гуйжиж байсан 7-н сартай Зулекха оролцов. Пастор Гилын залбиралын дараа хөл нь тэгширэн засрав. Үүнээс гадна эдгэрэл адислалуудыг хүлээн авцгаасан маш олон хүмүүс Бурхандаа алдар сууг талархан өргөв.

## ◆ Равалпиндид Гэрчиллүүд Ундрэн Гарсаар Байв

Гуравдугаар сарын 24, 25-нд, Висе Бишоп Агуу Сургаал Номлол Ассемлеин Пастор Жоржын хүсэлтээр Пасторын Семинар болон Эдгээлтийн Адислал Крусайд зохион байгуулагдав. Пастор Гил гуайн алчуурт залбиралаар, Рут Давит (55 настай эмэгтэй) нүдний болор цайлтаас болж зүүн нүдэндээ хараагүй болсон байсан ба тус уулзалтаас болж хараа оров. Емануел (73 настай эрэгтэй) цус харвалтаас болж алхаж чадахгүй болсон байсан бас залбиралт уулзалтын дараа ямар нэгэн тусламжын зүйлсгүйгээр алхаж чаддаг болов. Азиз-ул-син (64 настай эрэгтэй) баруун суганыхаа дор маш том хавдартай байсан ба залбиралын дараа маш багассан байв. Мөнтүүнчлэн, тэрбээр гараа өргөж чадаж байв. Чихрийн шижинг өвчинөөс болж хөдөлгөөнгүй болон чиргүүлэн дээр нэгэн өвчтөн ирсэн байсан ба залбиралын дараа 14 хоногын дараа ярьж эхлэв. Иймэрхүү өвчин зовлонгоосоо ангижирсан маш олон гэрчиллүүдээр дүүрцгээж байв.

## ◆ Доктор Лее гуайн сургаал номлол програмуудаас Карачийнхан адислал энэрэлийг хүлээн авцгаав

Гуравдугаар сарын 25-нд, номлолын багынхан Карачийн ТВ-ынхэнтэй уулзан сургаал номлол цацан нэвтрүүлэх талаар Изаак ТВ-ын ерөнхийлөгч Пастор Анвар Фазал болон Асиф Назир нартай уулзажээ. Тэд, «Карачийнхэн Доктор Лее гуайн сургаал номлолуудыг Изаак ТВ-гээр цацан нэвтрүүлэхийг хүсэцгээж байдаг билээ» хэмээн хэлэв. Одоогын байдлаар Изаак ТВ-тэй нэвтрүүлэх гэрээ контракт хийсэн билээ. Зарим каблийн ТВ-ийн станцууд нь Ислам юм. Изаак ТВ нь GSN TV (www.gcntv.org) Доктор Лее гуайн сургаал номлолууд болон Манмин сүмийн тоглолтууд өдөрт найман цаг цацан явуулахаар болов.

## ◆ Хидерабадын Пасторуудын Холбоо нь Манмин сүмийн салбар сүмээр нэгдэн оров

Гуравдугаар сарын 26-нд, номлолын баг нь хоёр сая гаруй хүн оршин суух нэгэн Хидерабад хэмээх хотод айлчилан очив. Тус хотод нийт гучаас дөчин пасторууд байдаг ба хорь гаруй нь Хидерабад Пасторуудын Холбооны гишүүд юм. Тус семинаруудын өглөөний үйл ажиллагаанд оролцоцгоосон пасторууд, «Ийм гайхамшигт учир утга агуулгатай сургаал номлолуудыг сонсон суух боломжтой байсан нь үнэхээр агуу гайхамшигт адислал юм» хэмээн хэлцгээв. Семинаруудын дараа тус Холбооны бүх гишүүд Манмин сүмийн салбар сүм болцгоон бүртгэгдэн орцгоов. Оройн үйл ажиллагаанд дээр Агуу Гайхамшигт Эдгээлтийн Крусайд дээр Бурханы агуу гайхамшигт үйлс биелэлээ олцгоов. 75 настай Субаха Масих гэдэг нэгэн хүн хоёр жилийн өмнө нүдэндээ хагалгаанд орсон боловч хараагүй болсон байв. Алчуурт адислал залбиралыг хүлээн авсаны дараа түүний баруун нүдэнд гэрэл гэгээ үзэгдэн хараа орон сайн хардаг болов.


### Монгол Манмин Төв Сүм

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

#### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
 www.manmintv.org